

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 6 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Зүмбэрэллхамаар ахлуулсан ажлы хэсэг 2019 оны 06 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд манай аймагт ажиллаж Төрийн албаны тухай хууль болон холбогдон гарсан дүрэм журмуудаар нийт 56 байгууллага, 24 сумын 250 гаруй төрийн албан хаагчдад сургалт мэдээлэл хийж, сонирхсон асуултуудад хариул өгч ажиллалаа. Энэ үеэр Аймгийн Засаг даргын Тамгын газар болон Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаатай танилцаж, төрийн албанд ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан ахмадууд, Төрийн албаны салбар зөвлөлийн гишүүдтэй уулзаж мэдээлэл өгч ажиллалаа.

Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн удирдах ажилтны семинар дээр өгсөн үүрэг даалгаврын 2-р улирлын хэрэгжилт, аймгийн Засаг дарга Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргатай байгуулсан 2019 оны гэрээний хэрэгжилтийг хагас жилийн байдлаар тооцон хяналт шинжилгээ үнэлгээ хийлгэж холбогдох газарт нь хүргүүлээ.

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн ажлын хэсэг 6 дугаар сарын 12-14-ны өдрүүдэд Хөвсгөл аймагт ажиллаж, аймгийн ЗДТГ 92%-тай дүгнэгдлээ.

ХБНГУ-ын Барут Марк хот, Мөрөн сумын хамтын ажиллагааны хүрээнд баригдсан “Бидний байшин” сургалт мэдээллийн төвийн барилга хүлээн авах үйл ажиллагаа зохион байгуулагдлаа.

БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны байгууллага (KOICA) 2019 оны 6 дугаар сарын 27,28-ны өдрүүдэд Хөвсгөл аймагт ажиллалаа. Энэ үеэр аймгийн Засаг даргатай уулзаж, "Сайн дурын ажилтан томилох хөтөлбөр"-ийн талаарх танилцуулгыг төрийн байгууллагуудын 50 орчим албан хаагчдад хийлээ

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:

Төрийн сангийн төлбөр тооцооны программаар 2019 оны 6-р сард 46 Төсөвт байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас 21,9 тэрбум төгрөгний 2,608 ширхэг гүйлгээ шивэгдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн 2019 оны 5-р сарын мэдээгээр Орон нутгийн орлого, санхүүжилт 3.493,8 сая төгрөгний төлөвлөгөөтэйгээс 4.245,7 сая төгрөг буюу 121.5% хувийн гүйцэтгэлтэйгээр давуулан биелүүсэн байна.

Орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарлагын гүйцэтгэл батлагдсан төсөв 50.443,6 сая төгрөг байгаа бөгөөд үүнээс 23.481,7 сая төгрөг нь тусгай зориулалтын шилжүүлгээс, 22.564,8 сая төгрөг нь орон нутгийн байгууллагуудад олгох санхүү дэмжлэг болон аймаг сумын орлогоос, 136.780,1 сая төгрөг нь төсөвт байгууллагын өөрийн орлогоос, 3.283,5 сая төгрөг нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тус тус санхүүжигдсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээнд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 50.443,6 сая төгрөг, Зарлагын гүйцэтгэл 49.630,7 мянган төгрөг буюу 98,4% хувьтай байна. ТЗШ-ын санхүүжилт болон санхүүгийн дэмжлэг бүрэн ирсэн. ОНХС-ийн санхүүжилт дутуу ирсэн. Үндсэн үйл ажиллагааны орлого өндөр давалттай байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Төсвийн нийт авлага 1.054,4 сая төгрөг өмнөх сараас 54,7 сая төгрөгөөр буурсан байна. Нийт өглөг 1.533,4 сая төгрөг өмнөх сараас 193.5 сая төгрөг өссөн байна.

Аймгийн 2018 оны давсан орлого, дансны үлдэгдлийг аймгийн ИТХ-ын хуралдааны 2019.04.03-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталж нэн тэргүүнд шаардлагатай арга хэмжээ, хөтөлбөр төслүүдэд хуваарилагдсан байна.

Үндэсний Статистикийн хорооноос зохион байгуулан явуулж байгаа Өрхөд суурилсан нийгэм эдийн засгийн судалгаа, ажиллах хүчний судалгааг түүвэрт сонгогдсон Баянзүрх, Жаргалант, Тосонцэнгэл, Цэцэрлэг, Цагааннуур, Их-Уул, Төмөрбулаг, Мөрөн сумын 1,8,14 дүгээр багийн нийт 80 өрхөөс заавар, аргачлалын дагуу таблетаар авлаа. Мөн цаг ашиглалтын судалгаанд хамрагдсан 6 сумын 120 өрхөөс судалгааг авч байна. Өргөн хэрэглээний үнийн мэдээг 7 хоног бүрийн Лхагва гарагт ҮСХ-оос ирүүлсэн программд шивж байна.

Гурав. Хууль эрхзүйн бодлогын хүрээнд

Аялал жуулчлалын улирал эхлэж байгаатай холбогдуулан аймгийн МХГ-аас хүнсний захын үйл ажиллагаа эрхлэгчид, худалдааны газрууд, Хатгал тосгоны худалдаа үйлчилгээ эрхлэгч зэрэг нийт 160 гаруй иргэнд 3 удаагийн салбарын сургалтыг зохион байгуулж, хүнсний аюулгүй байдал, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлээр мэдээлэл өглөө.

МХЕГ-аас ирүүлсэн 01/48 удирдамжийн дагуу Мөрөн сумын нийтийн эзэмшлийн зам талбай, хүүхдийн тоглоомын газар, хүүхдийн парк, зэрэг газруудын цахилгааны аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 18 зөрчил дутагдлыг илрүүлж ашиглагч Хот тохижуулалт ХХК-аар аюулгүй байдлыг хангуулсан

Хөвсгөл нууранд усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд Зам, тээвэр хөгжлийн яамны Далайн захиргаа, Онцгой байдлын газар, Байгаль орчны яам зэрэг байгууллагатай хамтран 3 өдрийн сургалтыг зохион байгуулж 20 аж ахуйн нэгж, 62 иргэнийг хамрууллаа. Мөн дээрх байгууллагуудтай хамтран усан замын тээврийн хэрэгслийн үзлэг оношлогоог хийж илэрсэн 42 дутагдлыг газар дээр нь арилгуулж, усан замын тухай хууль болон холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг хангууллаа.

Аймгийн хэмжээнд хулгайн нүүрс, мод тээвэрлэлтэд хяналт тавих зорилгоор Хилэнтийн гүүр, Улаанбаатар хот гарах, Хатгал тосгоны замуудад 24 цагийн хяналтын пост ажиллуулж байна.

Архидан согтууралтай тэмцэх чиглэлээр ТББ-тай хамтран АА цугларалтыг 180 архины хамаарал бүхий иргэдийн хамруулан зохион байгуулсан.

Мод бэлтгэх эрхийн гэрчилгээ олгодог нэгжүүдэд хяналт хийж зөрчлийг таслан зогсоож ажилласан.

“Орон нутгийн зам- Хөдөлгөөний соёл 2019” арга хэмжээг зохион байгуулж зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх олон төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн нэгдсэн үйл ажиллагааг аймгийн хэмжээнд зохион байгуулж, 2019 онд улсад амжилт гаргасан сурагчдыг шагнаж, урамшууллаа.

Элсэлтийн ерөнхий шалгалтыг зохион байгуулж 710 хүүхэд шалгалтад орсон ба Их дээд сургуулийн Консерциумтай хамтран 12-р анги төгсөгчдийн мэргэжил сонголтын үйл ажиллагааг зохион байгуулж, 496 хүүхэд их, дээд сургуульд элсэн орох эрхтэй боллоо.

Аймгийн БСУГ, Дэлхийн Зөн ОНХ-тэй хамтран 5 сая төгрөгийн шагналын сан бүхий "Бид ном унших дуртай" аянаа дүгнэлээ. Энэхүү аянд 32 сургуулийн номын клубын 1000 гаруй сурагч идэвхитэй оролцож сурагчдад чиглэсэн олон төрлийн үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлж үр дүнд хүрсэн байна.

ОУ-ын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр "Хүүхэд хамгаалал – Өрхийн хөгжлийг дэмжих" нэрлэсэн жилийн хүрээнд "Соёл урлаг" - ийн салбаруудын хамтарсан цогц үйлчилгээнд ОНС Музей Хүүхдүүдэд Монгол үндэсний тоглоом наадгайг танилцуулах, тоглоомыг тоглуулж, мартагдаж буй тоглоом наадгайг заан сургах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор "Монгол наадгай" боловсролын хөтөлбөр болон амьтдын гэрэл зураг, "Богцон дахь музей" боловсролын хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн хийсэн бүтээлийн дээжис түр үзэсгэлэн, ХДТ-ын "Улаан малгайт" таягт жүжиг, Төв номын сан "Гэр бүл" номын үзэсгэлэнгээр хүүхдүүдэд үйлчиллээ.

Аймгийн БСУГ, АНУ-ын Монтана мужийн эгч дүү орнууд төсөл, Бүрэнтогтох сумын Засаг даргын Тамгын газар хамтран "Хотгойдын урлаг соёлын наадам"-ыг 2019 оны 06 сарын 23-24-ний өдрүүдэд зохион байгууллаа. Энэхүү наадамд Цэцэрлэг, Цагаан-Уул, Бүрэнтогтох, Арбулаг, Алаг-Эрдэнэ, Түнэл, Тосонцэнгэл, Их-Уул, Төмөрбулаг, Мөрөн сумын 160 гаруй ардын авьяастнууд оролцлоо. Урилгаар Шинжлэх ухааны академийн түүх, археологийн хүрээлэнгийн захирал академч С.Чулуун, Шинжлэх ухааны академийн философийн тэнхимийн захирал Пүрэвсүрэн, УГЗ Ч.Дагвадорж, Ховд аймгийн Мянгад сумын засаг дарга, ИТХ-ын дарга, Соёлын төвийн хамт олон хүрэлцэн ирж хүндэтгэл үзүүллээ.

Азийн ардын урлагийн наадамд 12 орны 200 гаруй оролцогч, үндэсний 1700 гаруй оролцогч авьяас чадвараараа өрсөлдсөн ба Эрдэнэбулган сумын ардын авьяастан С.Бямбажав гуай язгуур урлагийн хоолой лимбэ төрөлд 2-р байранд шалгарлаа.

Олимпын аварга Жон Петерсоны нэрэмжит Чөлөөт бөхийн ОУ-ын тэмцээнээс эмэгтэй 55 кг-ын жинд М.Туул мөнгөн медаль, эрэгтэй 79 кг-ын жинд М.Содномцэрэн мөнгөн медаль, эмэгтэй 70 кг-ын жинд Э.Энхмөрөн, эрэгтэй 94 кг-ын жинд Э.Дамдинжав нар 5 дугаар эзэлсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн суугаа волейболын УАШТ 2019 оны 6 дугаар сарын 6,7-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдаж манай аймгаас эрэгтэй, эмэгтэй 34 тамирчин оролцож багийн дүнгээр 4 дүгээр байр эзэллээ.

Нийтийн бүжгийн УАШТ Улаанбаатар хотод зохион байгуулагдаж манай аймгаас 32 тамирчин оролцсоноос Ахмад настны төрөлд багаараа хүрэл медаль хүртсэн амжилттай оролцлоо.

Тайваны Хүүхэд гэр бүлийг дэмжих сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй "Хязгаар нутгийн инээмсэглэл" төслийн хүрээнд Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эрүү нүүрний мэс заслын тасгийн болон бөөрний мэс заслын эмч нарын хамтарсан 15 хүний бүрэлдэхүүнтэй баг аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2019 оны 06 дугаар сарын 24-нөөс 07 дугаар сарын 01 хүртэлх хугацаанд ажилласан. Энэ үеэр уруул тагнайн сэтэрхий эмгэгтэй, шүдний гажиг засал, хэл заслын болон бөөрний мэс засал шаардлагатай өвчтөнүүдэд нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламж үйлчилгээг 114 хүнд үзүүлж, 56 хүнд үнэ төлбөргүй хагалгаа хийсэн.

Аймгийн Засаг даргын санаачлагаар "Хавдрын эсрэг үндэсний аян"-ныг орон нутагт 2019 оны 6 дугаар сарын 17-21 өдрүүдэд зохион байгуулж, Хавдар судлалын үндэсний

төвийн 13 эмч, мэргэжилтэн 7 нарийн мэргэжлийн чиглэлээр ажиллаж давхардсан тоогоор 1574 хүнд үзлэг оношилгоо хийж, хортой хавдар 10, хортой гэж сэжиглэгдсэн 23, хоргүй хавдар 106, хавдрын урьдал өвчин 104, хяналтын 120 хүн, бусад өвчтэй 950 хүнийг үзэж оношилсон байна.

УИХ-ын гишүүн УИХ-ын дэд дарга Л.Энх-Амгалангийн санаачлага дэмжлэгтэйгээр 6 сумын 19 багт Улаанбаатар хотын төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын хамтарсан баг ажиллаж, эмэгтэйчүүд, ЭХО, дотор, сүрьеэгийн чиглэлээр нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, оношилгоо хийж нийт 3000 орчим иргэнд хүрч үйлчлэн газар дээр нь эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээг үзүүлсэн.

ЭМГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу 2019 оны 06 сард Галт, Жаргалант, Шинэ-Идэр, Төмөрбулаг сумдад аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нар эрүүл мэндийн багцын үзлэгийг зохион байгуулж, багцын үзлэгээр 903 хүн хамрагдсан.

Аймгийн Засаг дарга Орхон аймаг дахь “Медипас” хувийн эмнэлэгтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулан гэрээний дагуу аймаг, сумдын төрийн албан хаагчдыг эрүүл мэндийн урдчилан сэргийлэх үзлэг оношлогоонд хамруулах үйл ажиллагааг 2019 оны 6 сард зохион байгуулж, эхний ээлжийн үзлэгт 40 төрийн албан хаагч хамрагдаж, үзлэг оношлогоогоор хорт хавдартай 2 төрийн албан хаагч шинээр бүртгэгдэж шатлалд илгээгдсэн байна. Үзлэгийн үйл ажиллагааны холбогдох зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж, дэмжлэг үзүүллээ.

ЭМГ-ын пейж хуудсанд айл өрх хувь хүмүүсийн заавал хэвшүүлэх эрүүл мэндийн 13 дадлыг байршуулсан нийт 58395 хүн (давхардсан тоогоор) үзсэн ба хамгийн их хандалтыг 6 дахь дадал буюу (Өглөө өлөн явахгүй, орой хоол идэнгүүт хэвтэхгүй, цайг хэт халуунаар уухгүй байх, хоол цайны давсыг аль болох бага хэмжээгээр хэрэглэж хэвшин, давсыг өдөрт нэг хүнд 5 граммаас бага болгох)-ыг 15569 хүн үзэж, 126 шэйр, 70 лайк хандалт авсан байна. Тус пейж хуудсанд 13 төрлийн эрүүл мэндийн чиглэлийн зөвлөгөө, сэрэмжлүүлэг мэдээлэл, 5 төрлийн шторк, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тухай бүр байршуулан улмаар улирлын чанартай “Наршилтаас сэргийлье”, “Тарваган тахал өвчнөөс сэргийлье”, “Үерийн аюулаас сэргийлье” зэрэг мэдээлэл зөвлөгөөг тус тус байршуулан иргэдийг мэдээллээр ханган ажиллалаа.

Дэлхийн тамхигүй өдөр, тамхины хор хөнөөлийн талаарх мэдээллийг Хөвсгөлийн долгио радио, Хөвсгөлийн өнгө пэйж хуудас, Түмний ТВ-ээр өгсөн ба Дэлхийн зөнгийн төгсөлтийн аргачлалын 180 өрхөд хийх сургалтын удирдамжийг батлуулан 3 ээлжээр 71 хүнийг сургалтанд хамрууллаа. Мөн “Хөвсгөлийн долгио” радиод “Хүүхдийн хоол тэжээл” зөвлөмж, ярилцлагыг өгсөн. Дэлхийн сүүний өдрийг тохиолдуулан “Эхийн сүүгээр хооллолтын ач холбогдол” гарын авлагын эхийг ХХААГ-т хүргүүлэн нэгдсэн арга хэмжээний үеэр тусгай сонгогдсон сурталчилгааны багаар олон нийтэд түгээлгэсэн.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:

2019 онд үр тариа 16684 га үүнээс улаанбуудай 16548 арвай 120, хөх тариа 16 гурвалжин будаа 9, рапс 2369, малын тэжээл 871, төмс 235,55, хүнсний ногоо 178,7 га-д тус тус тариаллаа.

Эх үрсийн баяраар НҮБ, ХХААБ-ын “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн санаачлагыг дэмжин аймгийн ЗДТГ, ЭМГ, МХГ, ГБХЗХГ, аймгийн сүү боловсруулах үйлдвэр Титаник ХХК -тай хамтран “Дэлхийн сүүний өдөр”-ийг анх удаа аймагтаа “Эх орны сүү – Эрүүл хүнс” уриан дор тэмдэглэлээ. Энэхүү арга хэмжээний хүрээнд эцэг эх, хүүхдүүдэд сүүний үнэт чанар хэрэглээний ач холбогдлыг сурталчилсан гарын авлага материалыг хүүхэд эцэг эхчүүдэд тараан 350 гаруй хүүхдэд сүү, тараг, ааруул зэрэг сүү цагаан идээг олгож, “Хүн бүр өдөрт нэг аяга сүү”-г заавал хэрэглэж хэвшихийг уриаллаа.

МУЗГ-аас хэрэгжүүлж буй “Мах сүүний анхдугаар аян”-ы хүрээнд ХХААХҮЯ, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “ХАА-н нэмүү өртгийн сүлжээг дэмжих техник

туслалцаа” төсөлтэй хамтран мал аж ахуйгаас бэлтгэж буй сүү ашиглалтыг сайжруулах, малчдын орлогыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн хөгжүүлэх зорилгоор “Ногоон алт” төсөл хэрэгжиж буй Улаан-уул, Алаг-эрдэнэ, Арбулаг сумдын БАХ-ны гишүүн 22 малчин өрх болон Мэлхий хадны цуурай, Дархад малын хишиг ундрах хоршоонд нийтдээ 61,2 сая.төгрөгний үнэ бүхий багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг гардуулан өглөө.

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор ХХААХҮЯ-наас хуваарласан тэрбум төгрөгийн зээлийн эх үүсвэрийн хүрээнд ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн А-119 дугаар тушаалаар батлагдсан “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам” - ын дагуу 5 дугаар сарын 27-ны өдрөөс 6 сарын 10-ны өдөр хүртэл 69 төслийг иргэд ААНБ-аас хүлээн авлаа.

АЗДТГ,ХХААГ, Хөвсгөл нуурынбайгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төсөл хамтран “Тогтвортой мал аж ахуй эрхлэлт” аймгийн малчдын зөвлөгөөнийг 6-р сарын 21-ний өдөр зохион байгуулж, 23 сум 1 тосгоны Засаг дарга, Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн, Газрын даамал, 126 багийн малчдын төлөөлөл нийт 300 гаруй хүн оролцсон.

2019 онд 2545600 толгой хээлтэгч мал төллөхөөс нийт 1883214 толгой хээлтэгч үүнээс ингэ 287, гүү 51330, үнээ 124611, эм хонь 1027425, эм ямаа 679561 мал төллөж, 1836997 толгой төл бойжиж үүнээс ботго 278, унага 49797, тугал 121618, хурга 1005677, ишиг 659627 толгой байна. Төлөлтийн хувь 74,0, төл бойжилт 97,5 хувьтай байна. Оны эхнээс 41376 толгой мал хорогдож үүнээс тэмээ 4, адуу 1490, үхэр 4013, хонь 17812, ямаа 18057 мал хорогдож оны эхний малаас 0,7 хувь нь хорогдсон байна

Мал, амьтныг халдварт өвчнөөс урьдчилан арга хэмжээг зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын А/129 тоот захирамжаар 14 нэр төрлийн халдварт өвчний урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 710,0 мян мал, амьтан буюу 61,5% хамрагдаж, 17 сумын 39 нэгжийн дархлаажуулалтын нэгдсэн тайлан, санхүүгийн анхан шатны материалыг хүлээн авч, ажил үйлчилгээний хөлс 123,0 сая төг олгож, хянан баталгаажуулалт хийлээ.

Шүлхий, бог малын мялзан өвчнөөр эрүүл бүс нутгаа нотлох тандалт судалгааг Эрдэнэбулган, Галт, Алаг-Эрдэнэ сумын 6 багийн 45 өрхийн 675 малаас санамсаргүй түүврийн аргаар цусны дээж цуглуулан, ЭЛИЗА урвалаар шинжилгээ хийж байна.

Шимэгчтэх өвчинтэй тэмцэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан шимэгчтэх өвчний эсрэг эм бэлдмэл, угаалга, туулгалтын бодис импортолдог аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан ажиллаж байна.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:

Байгаль орчин аялал жуулчлалын яам, Аялал жуулчлалын ур чадварын төв, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг соёл урлагийн газар хамтран "Аялал жуулчлалын үйлчилгээний чанарыг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх" төслийн хүрээнд 2019 оны 06 сарын 12-15-ний хооронд дараах чиглэлээр мэргэжлийн багш нар сургалт зохион байгууллаа. Үүнд: Тогооч, зочин хүлээн авагч, өрөө, гэрийн үйлчлэгч, зөөгч, бартендер бариста, хаалгач, ачаа зөөгч, аяллын хөтөч, аяллын жолооч, удирдлага, менежер чиглэлээр сургалт зохион байгуулагдаж, аймгийн Соёлын төвийн соёлын өв хариуцсан ажилтнууд, аймгийн музейн хамт олон, аяллын хөтөч, тайлбарлагчийн сургалтад хамрагдлаа. Нийт 10 чиглэлээр 5 өдөр 303 хүн сургалтад хамруулж, мэргэжлийн үнэмлэх гардан авсан.

“Хандлагаа өөрчилъе” багц ажлын хүрээнд аймгийн төвийн 9 сургуулийн ногоон паспорт эзэмшигч сурагчдын төлөөллөөс бүрдсэн БОАЖГ-ын дэргэдэх “Green development” сурагчдын эко зөвлөл байгуулж, хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр 6-р сарын 1-нд “2 хуруу зай-1 дурсамж” аяныг өрнүүллээ. Аяны хүрээнд олон нийт, хүүхдүүдэд бидний хэрэглээнээс гардаг бүх төрлийн зай хураагуур байгальд хаягдсанаар ямар хор нөлөөтэйг сурталчилж, нэг

хураа зай хөрс, усыг хэрхэн бохирдуулдаг талаар мэдээлэл 2 ширхэг дууссан зай авчирсан хүүхдийн 1 дурсамжтай зургийг үнэгүй угааж өгөх ажлыг хэрэгжүүлж, 50 гаруй зай хураагуур цуглуулж, цуглуулсан зайг БОАЖЯ-ны дэргэдэх Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвд хүргүүлсэн.

БОАЖГ, Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын захиргааны хамт олон хамтран, Хөвсгөл нуурын эргээр аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа гэр буудал, баазуудаар явж, 2018 онд өгсөн үүрэг даалгаврын биелэлттэй танилцан 98 ААНБ-аар орж, 22 ус ашиглагчид дүгнэлт гаргаж, өмнө жилийн дүгнэлттэй болон шинээр дүгнэлт гаргуулсан ус ашиглагчтай гэрээ байгууллаа. Мөн бохирын систем, ариун цэврийн байгууламжийг шалгаж, аялал жуулчлалын мэдээллийн санг шинэчлэх ажлыг хийлээ.

Хөвсгөл нуурыг хүн ба шим мандлын дэлхийн нөөцөд бүртгүүлэх урьдчилсан хэлэлцүүлэг 2019 оны 06-р сарын 28-30-ний өдрүүдэд Хатгал тосгонд боллоо. UNESCO-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Бээжин дэх салбарын мэргэжилтэн, шинжээчид, БОАЖЯ, УТХГ, АЗДТГ, БОАЖГ, УЦУОШТ, ГХБХБГ, мэргэжлийн байгууллагын төлөөллүүд, төсөл хөтөлбөрүүд, холбогдох сумдын төлөөлөл зэрэг 50 гаруй төлөөлөгчид хуралдаж, эхний ээлжийн мэдээлэл авах, цаашдын ажлын төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлэх, дэлхийн өвд хэрхэн нэр дэвшүүлэх талаарх чиглэлээ гаргалаа.

2019-06-03-аас 06-ны өдрүүдэд аймгийн БОАЖГ, Монголын тул сан, Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын захиргаа, Хөвсгөлийн Улсын Тусгай Хамгаалалттай Газрын хамгаалалтын захиргаа, аймгийн Онцгой байдлын газар, ТВ-9 телевиз, Хөвсгөл нуурын байгалын цогцолбор газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлал хөгжүүлэх нэгдсэн төсөл /МОН-9183/ хамтран “ЦЭНГЭГ ЭГИЙН ГОЛОО ЦЭВЭР АРИУН БАЙЛГАЯ” уриатай Эгийн голын эхнээс, Эг-Үүрийн бэлчир хүртэлх 700 гаруй км газарт бүх нийтийн хог цэвэрлэгээг зохион байгууллаа.

Азийн Хөгжлийн банкны зээлээр Мөрөн суманд цэвэрлэх байгууламж барих ажлыг “Набсан” ХХК гүйцэтгэхээр 06 дугаар сарын 25-нд шав тавьж, барилга угсралтын ажлыг эхлүүлээд байна

Барилга, хот байгуулалтын яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Барилгын хөгжлийн төвтэй хамтран 21 аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилгын хэлтсийн дарга, аймгуудын Ерөнхий архитекторуудын сургалтыг Хатгал тосгонд амжилттай зохион байгууллаа. Сургалтаар барилгын салбарын хууль, эрх зүйн орчин, хот тосгоны дахин төлөвлөлтийн чиглэлээр мэдээлэл солилцож, Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлэг зэргийг амжилттай зохион байгууллаа.

Долоо. Сум, орон нутгийн талаар

Мөрөн сумын Засаг даргын Тамгын газар, ИТХ-ын ажлын албатай хамтран Дулаанхан уулын овоо тахилга бэсрэг наадмыг 2019 оны 06 дугаар сарын 12-нд зохион байгууллаа. Бэсрэг наадмын үеэр хурдан даага, соёолон насны морьд уралдаж, хүчит 32 бөх барилдаж, нарийн мэргэжлийн эмч нар иргэдэд үнэ төлбөргүй үзлэг оношлогоо хийлээ.

Мөрөн хот үүсч хөгжсөний 210 жилийн ойн хүрээнд сумын Засаг даргын Тамгын газар “Шагайн холбоо”-той хамтран "ТУЛТЫН ТОХОЙН ТОЙРОМ-2019" шагайн харвааны тэмцээнийг 2019 оны 06 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тэмцээнд Хөвсгөл аймгийн 11, Орхон аймгийн 1, Булган аймгийн 3, нийт 15 багийн 120 гаруй харваачид оролцлоо.

Мөрөн хотын өнгө үзэмжийг нэмэгдүүлэх, сэргээн засах, нийтийн эзэмшлийн талбайн тохижилтыг хийх зорилго бүхий "Өнгөлөг Мөрөн" төслийг 2019 оны 06 дугаар сарын 18-аас эхлүүлээд байна. Төслийн хүрээнд ажил идэвхтэй хайгч 36 иргэнийг түр ажлын байраар хангаад байна.

Алаг-Эрдэнэ суманд “Засаг орон сууц-3” хөтөлбөрийн хүрээнд Төсвийн байгууллага, аж ахуйн нэгж, нөхөрлөлүүдийн хандив тусламжаар хамтарч 6 х 6 хэмжээтэй хашаа байшинг 6.5 сая төгрөгөөр барьж 5 хүүхэдтэй өрх толгойлсон Н. Анхцэцэгт хүлээлгэж өгсөн. Мөн ЗИС-30” сарын аяны хүрээнд сумын төсөвт байгууллагуудыг 7 багт хувааж бүтээлч ажил болон иргэдийг соён гэгээрүүлэх ажлуудыг хийж 27.1 сая төгрөгийг зарцуулсан байна. ”Нэг төрийн албан хаагч нэг зорилтот өрх” аяныг зохион байгуулж 105 төрийн албан хаагчид 105 өрхийг хариуцуулж эрүүл мэндийн чиглэлээр тусламж үйлчилгээг үзүүлж, сургалт, сурталчилгаа мэдээ, мэдээллээр хангаж ажилласан байна .

Чандмань-Өндөр сумын эмэгтэйчүүдийн зөвлөлийн санаачилгаар эмэгтэйчүүдийн чуулганыг зохион байгуулж нийт 126 эмэгтэй төлөөлөгчид оролцон “Хүүхэд хүмүүжүүлэх уламжлалт арга ухаан” сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлэг өрнүүлэхийн зэрэгцээ өрх толгойлсон эмэгтэйчүүдэд тусаллаа. Спортын 10 төрлөөр баг, байгууллага, хорооллуудын дунд “Бага олимп” спортын наадам зохион байгуулж тэмцээнд нийт 330 тамирчид 130 багц медалийн төлөө өрсөлдөж, улмаар 8 өрхийн орон гэрийн асуудлыг шийдвэрлэлээ.

Эрдэнэбулган сумын ИТХ-ын төлөөлөгчид “Төлөөлөгчийн нэг өдөр” үйл ажиллагааг тусгай удирдамжийн дагуу хөдөөгийн 4 багт зохион байгуулан ажиллаж уралдаан тэмцээн явуулж, сургалт мэдээлэл хийж, хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг сонсголоо.

Галт суманд “Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллагатай хамтран 4 багийн 11 өрхийг малжуулах ажлыг зохион байгуулж өрх тус бүрт 3 тугалтай үнээг гардуулав. Мөн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор ДЗМОУБ-д хандан арьс шир боловсруулах тоног төхөөрмж, оёдлын машин, мужааны багаж хэрэгсэлийг иргэдийн бүлэгт гардуулан өгч сумын удирдлагаас цехийн байрны асуудлыг шийдвэрлэлээ. Сумын эрүүл мэндийн төв нь өргөтгөлийн шинэ байрандаа үйл ажиллагаагаа эхлүүлж “Дэлхийн зөн” ОУБ-тай хамтран нярайн чийрэгжүүлэлтийн бүтээгдэхүүн авч багийн нүүдлийн амбультороор дамжуулан чийрэгжүүлэлт хийж байна.

Хатгал тосгонд Хөвсгөл нуур, Эгийн гол дагуу хог цэвэрлэгээ явагдлаа. Хог цэвэрлэгээнд 5 ойн мэргэжлийн байгууллага, 3 ойн нөхөрлөл, 8 төсөвт байгууллага болон ТББ нийт 17 байгууллага оролцлоо.

Хөх Лусын их тахилга буюу Хөвсгөл далайн дэлгэр их тахилга энэ зуны дунд сарын шинийн 14 буюу 6 дугаар сарын 16-нд Ханх, Чандмань-Өндөр Алаг-Эрдэнэ Хатгал Ренчинлхүмбэ сумдын нутагт орших 4 Сант хайрхадын тахилгаар ёслол төгөлдөр боллоо. Тахилгад аймгийн Гэтэлгэгч Эх төв болон Мөрөнгийн Хүрээ Гандандаржаалин хийдийн лам нар Энэтхэг орноос зорин морилсон Гэвш Лхарамба Жавзандорж оролцлоо.

“Усан замын тээврийн аюулгүй ажиллагаа” сэдэвт семинар Хатгал тосгоны “Leona resort” жуулчны баазад боллоо. Семинарт Онцгой байдлын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, ХУТХГХЗ, “Монгол ус” ТӨААТҮГ, “Хөвсгөл далай ээж нийгэмлэг” ТББ, Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж иргэд, завь жолоодогчид оролцлоо. Энэ үеэр орон нутгийн захиргааны байгууллагын төлөөлөл мөн татварын байцаагч, эрүүл мэнд, нийгмийн даатгалын байцаагч нар мэдээлэл хийлээ.

Хөвсгөл нуурыг хүн ба шим мандлын нөөц газруудын дэлхийн сүлжээнд бүртгүүлэх урьдчилсан хэлэлцүүлэг сургалт зохион байгуулагдлаа. Сургалтыг БОАЖЯ, Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар, ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс, ЮНЕСКО-ийн Бээжин дэхь төлөөлөгчийн газар, ХУТХГХЗ, Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргаа, тогтвортой аялал жуулчлалыг

хөгжүүлэх нэгдсэн төсөл хамтран зохион байгуулж аймгийн Засаг дарга болон орон нутгийн захиргааны байгууллагын удирдлагууд албан хаагчид, аялал жуулчлал эрхлэгчид оролцлоо.

“Эв модны наадам” буюу “Сур харваа 2019” наадам 2019 оны 06 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд ОХУ-ын Тункин аймагт зохион байгуулагдлаа. Энэхүү арга хэмжээнд Хатгал тосгоныг төлөөлж Захирагчийн орлогч Д.Баярдалай спортын төрөлд баг тамирчидаа авч оролцлоо.

Онцгой байдлын байгууллага нэгдсэн тогтолцоонд шилжисний 15 жилийн ойн баярыг тохиолдуулан Гал түймэр унтраах аврах 69 дүгээр ангиас Хатгал тосгоны гамшгаас хамгаалах ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн бэлтгэл бэлэн байдлыг шалгаж үзүүлэх сургалт зохион байгууллаа.

Тариалан суманд Монгол өрх сэтгэл зүйн хүрээлэнгийн сэтгэл зүйч Д.Баасанбатаар ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг суманд ажиллаж, нийгмийн хамгаалал, хөгжлийн хөтөлбөр болон сонгогдсон 152 өрхөд “Хэн ч надад үүнийг хэлээгүй”, “Хүүхэд хамгааллын тухай ойлголт”, “Хувь хүний хөгжил” сэдвүүдээр лекц уншиж, иргэдтэй санал бодлоо солилцлоо.

Тосонцэнгэл суманд “Төрийн үйлчилгээг багт” арга хэмжээг батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулж эрүүл мэнд, төрийн үйлчилгээг иргэдэд 5 багийн 342 өрхийн 423 иргэнд хүргэж ажилласан.

Ханх сум, Иркутск хотын “Ангасолка” зуслантай хамтран ажиллаж, ОХУ-ын 48 багш, сурагч Ханх суманд ирж амарч монгол ахуй, соёлтой танилцан тусгай хөтөлбөрийн дагуу уралдаан, тэмцээн, бусад арга хэмжээнд оролцлоо. Ханх сумын 27 сурагч 2 багшийн хамт тус зусланд амрахаар явлаа.

Бүрэнтогтох суманд олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр “Хүүхэд хамгаалал-Өрхийн хөгжлийг дэмжих” нэрлэсэн жилийн хүрээнд “Нэг төрийн албан хаагч-Нэг хүүхэд” аяныг үргэлжүүлэн өрнүүлж 160 гаруй төрийн албан хаагчид зорилтот өрхийн 180 хүүхдэд нийт 3.5 сая төгрөгийн эд хөрөнгийн туслалцаа дэмжлэгийг үзүүллээ.

Найм. Цаг үеийн бусад мэдээлэл

Мөрөн сумын 10, 11, 13, 14 дүгээр байруудын гэрэлтүүлгийн ажил, хуучин орон сууцны байруудын гадна фасадын ажил, 50/100 цогцолборын зам засварын ажил, Хатгал сумын захирагчийн албаны барилгын барилга угсралтын ажил, Мөрөн сумын дунд тойргийн хатуу хучилттай авто замын 3 байршилд богино холбоосын ажлууд дээр хяналт тавьж, улсын баяр наадмаас ашиглалтад оруулахаар ажиллаж байна.